

ЁС СУРТАХУУНТ ЭХ ОРОНЧ ҮНДЭСНИЙ ҮЗЭЛ СЭТГЭЛИЙН БОЛОВСРОЛЫГ БИЙ БОЛГОХ НЬ

Б.Лувсанравдан

Хилийн цэргийн Хил судлалын хүрээлэнгийн ахлах судлаач, доктор (PhD),
хурандаа

Товч агуулга: Энэхүү өгүүллээр ёс суртахуун ба эх оронч үзлийн харилцан хамааралд дүн шинжилгээ хийж, оюуны боловсролын зэрэгцээ сэтгэлийн боловсролыг хөгжүүлэх, төлөвшүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

Abstract: The aim of this article is to analyze the relationship between morality and patriotism and determine the way to develop and cultivate mental education along with intellectual education

Түлхүүр үгс: Ёс суртахуун, Эх оронч үндэсний үзэл, сэтгэлийн боловсрол.

Keywords: ethics, patriotism, mental and intellectual education,

Оршил

Дэлхийн улс, орнуудын нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдөн ил тод байдал, олон ургалч үзэл дэлгэрч, хүмүүс үзэл суртал, оюун санааны хувьд эрх чөлөөтэй болсноор материаллаг хэрэглээнд чиглэсэн ашиг, сонирхол нэмэгдэхийн зэрэгцээ шинжлэх ухаан, технологийн хөгжлийг даган бий болсон мэдээллийн хяналтгүй урсгалын нөлөөгөөр нийгмийн ёс суртахуун доройтож улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах, эх орныхоо хөгжил ирээдүйн сайн сайхны төлөөх эх оронч сэтгэлгээ, уламжлалт түүх, соёлоороо бахархах, тээн хөгжүүлэх, үндэсний ухамсар буурсан нь нийгэмд, нийтийн бус, явцуу ашиг сонирхол давамгайлах үндэс болсон.

Энэ бүх өөрчлөлтүүд нь сэтгэлийн боловсрол буюу нийгмийн ёс суртахууны үнэлэмж бууран, ёс суртахуун нь “хүнд заяасан үнэт зүйл” гэх ойлголт үгүй болж, эх орноо гэсэн үзэл хандлага нь явцуу ашиг сонирхолоор солигдсонтой шууд холбоотой юм.

Тийм учраас ёс суртахуун болон эх оронч үндэсний үзлийг ёс зүйн шинжлэх ухааны онолын үзэл баримтлалд нийцүүлэн нэгтгэж сэтгэлийн боловсрол гэх ойлголтыг бий болгож байна.

Нэг. Ёс суртахуун ба эх оронч үндэсний үзлийн хамаарал.

1.1 Эрх зүйн үндэслэл.

Монгол Улсад ёс суртахуун болон эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх, тэдгээрийг эх орны хөгжлийн чухал асуудал болгон томъёолсон эрх зүйн баримт бичгүүд олон байдаг ч түүнийг бид бүхэн төдийлөн сайн мэддэггүй. Тухайлбал

Монгол Улсын Үндсэн хуулийн зорилтод “...Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх...” гэж, Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалын 1.2.1 дэх хэсгийн “Эх оронч

үндэсний үзлийг дээдлэх” гэсэн заалтаар “Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлсээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх, эх оронч үндэсний үзэл, улс үндэстнийхээ сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхитэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно”, 3.3.3.1. “Нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйн төлөвшил, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, зөвшилцлийг хангах суурь болно..; 3.3.3.2. “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх...”, “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичгийн “...2.1.12. Иргэдийн эх оронч үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэх”, “...2.2.7.Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагуудыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитоор дэмжих”, “Алсын хараа-2050” үндэсний хөтөлбөрт “...хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай эх оронч, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх...”, 2023 онд шинээр батлагдсан Монгол Улсын “Боловсролын ерөнхий хууль”-ийн 4.1-т боловсролын зорилгыг “...хүн бүрт чанартай

боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцан ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх...” гэж, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 180 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Цэргийн нийтлэг дүрэм”-д цэргийн албан хаагчийн эрмэлзэх зүйлсийг “Эх оронч байх”, “Шударга байх”, “Эр зоригтой байх”, “Ёс зүйтэй байх” зэрэг агуулгаар тус тус тодорхойлсноор ёс суртахуунтай, эх оронч үндэсний үзэлтэй иргэдийн үүрэг, хариуцлага нь улс орны аюулгүй байдлын үндэс, хөгжлийн түлхүүр болох учиртайг төрийн бодлого болгон томъёолсон байна.

1.2. Их сэтгэгч, эрдэмтдийн дүгнэлт. Аристотел “...төрийн үүрэг бол ёс суртахууны дээд түвшинд хүрэх явдал учраас сайн үйлтнүүдийг хөгжүүлж, олшруулахад гол анхаарлаа хандуулах ёстой ...”, “иргэд нь эх оронч, үнэт чанарыг эзэмшсэн, шударга, ухаалаг байвал төр хүчтэй байна”, “...иймээс улс орны хөгжилд ёс суртахуунтай, ухаалаг, боловсролтой иргэдийн гүйцэтгэх үүрэг маш их...”¹, Оросын эрдэмтэн В.К.Левашов “...эх оронч үзэл гэдэг нь иргэдийн өөрийн эх орондоо хандах хандлагыг тодорхойлдог нийгэм ёс суртахууны зарчим юм...”, доктор Б.Бор “...Ёс суртахууны хүмүүжлийн хамгийн чухал хэсэг бол эх оронч үзэл мөн”, төрийн соёрхолт яруу найрагч Д.Урианхай “...Үүрэггүй эрх, хариуцлагагүй эрх чөлөө, хүн чанараас ангид ёс суртахуун хэвшил бол нийгмийг анархижуулах гажиг

¹ Чаньшев А.Н. Курс лекции по древней философии. -М.,1981. С.351

туйлшралын үндэс байх болно...”, доктор Б.Даш-Ёндон “Аливаа үндэстэн өөрийгөө ухамсарлаж байж үндэсний ухамсар үүснэ... үндэсний ухамсар бол тухайн үндэстний хүн нэг бүрийн сэтгэлийг хөдөлгөж чаддаг чавхдаст утас юм”, “Эх оронч үзэл гэж хүний ухамсарт орших улс төр, ёс суртахуун, байгал, нийгэм хүмүүжлийн мэдрэмж юм”, доктор Э.Энхмаа “Үндэсний ухамсар, үзэл бодол, итгэл үнэмшил, ёс суртахууны үнэлэмжийн нэгдмэл байдлыг хангах нь үндэсний эв нэгдлийг бүрдүүлэхэд ихээхэн нөлөөтэй”² гэх мэтээр эх оронч үндэсний үзэл, ёс суртахуун гэх ойлголтуудыг тодорхойлсон байдаг.

Дээрх эрх зүйн хэм хэмжээнүүд болон эрдэмтдийн дүгнэлтээс аливаа улсын хөгжилд нийгмийн ёс суртахуун, эх оронч үндэсний үзэл нэн чухал бөгөөд энэ хоёр ойлголт хоорондоо салшгүй уялдаатай болохыг харуулж байна.

Тиймээс эх оронч үзлийн талаарх эрдэмтэн судлаачдын дүгнэлт, эрх зүйн эх сурвалжуудад тулгуурлаж, уг ойлголтын талаарх уламжлалт ойлголтыг баяжуулан эх

оронч үндэсний үзлийг “Улс, эх орны эрх ашигт үйлчлэхэд чиглэгдсэн дэг журмыг сахих, эх орны эрх ашгийг явцуу эрх ашгаас ямагт дээгүүрт тавих хариуцлага, эр зориг, үндэснийхээ нэгдмэл үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, тээн өвлүүлэх ухамсар, үйл ажиллагаа бүхий ёс суртахууны мэдрэмж юм” хэмээн тодорхойлж болохоор байна. Энэхүү тодорхойлолтоос хууль дээдлэх, хариуцлага, эр зориг, үндэсний нэгдмэл үнэт зүйлс, ёс суртахуунтай байх гэсэн үндсэн ухагдахуунууд нь сэтгэлийн боловсролын агуулгыг илэрхийлсэн байна.

1.3. Ёс суртахуун болон эх оронч үндэсний үзлийн хамаарлын судалгаа.

Сэтгэлийн боловсролын гол асуудал болох ёс суртахуун, эх оронч үндэсний үзэлд хэрхэн нөлөөлөх, түүнийг төлөвшүүлэх үндсэн арга хэмжээг тодорхойлох зорилгоор төрийн алба хаагчдын төлөөлөл болгож Хил хамгаалах байгууллагын албан хаагчдаас, мөн энгийн иргэдээс судалгаа авахад дараах нөхцөл байдал харагдаж байна.

Хүснэгт 1. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас эх оронч үндэсний үзэлд нөлөөлөх нийгмийн эерэг хүчин зүйлсийг тодорхойлсон байдал

Та эх оронч үндэсний үзэлд нөлөөлөх нийгмийн эерэг хүчин зүйлсийг хэрхэн тодорхойлох вэ?	F	1=их/2=дундаж/3=бага		
		1	2	3
Түүх, соёл, уламжлал	1	110/58%	26/14%	53/28%
Гэр бүл, гишүүдийн харилцаа	9	41/22%	33/17%	115/61%
Иргэдийн ёс суртахуун	2	76/40%	68/36%	45/24%
Үндэс угсаа	4	73/38%	52/28%	64/34%
Боловсрол	3	74/39.1%	48/25.5%	67/35.4%
Нас	5	71/38%	72/38%	46/24%
Хүйс	10	35/19%	48/25%	106/56%
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	8	49/26%	63/33%	77/41%
Нийгмийн хүрээлэл	6	68/36%	65/34%	56/30%

² “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, хүн амын оюуны дархлааны асуудал” эрдэм

шинжилгээний хурлын эмхэтгэл-УБ., 33-34 дэх тал

Шашин шүтлэг	7	50/26.5%	55/29.1%	84/44.4%
--------------	---	----------	----------	-----------------

Хүснэгт 2. Иргэдээс эх оронч үндэсний үзэлд нөлөөлөх нийгмийн эерэг хүчин зүйлсийг тодорхойлсон байдал

Та эх оронч үндэсний үзэлд нөлөөлөх нийгмийн эерэг хүчин зүйлсийг хэрхэн тодорхойлох вэ?	F	1=их/2=дундаж/3=бага		
		1	2	3
Түүх, соёл, уламжлал	1	122/60%	53/26%	27/14%
Гэр бүл, гишүүдийн харилцаа	3	93/46%	59/29%	50/25%
Иргэдийн ёс суртахуун	2	104/51%	64/32%	34/17%
Үндэс угсаа	5	78/39%	87/43%	37/18%
Боловсрол	4	92/46%	75/37%	35/17%
Нас	6	78/39%	80/39%	44/22%
Хүйс	10	72/36%	89/44%	41/20%
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	5	93/45.9%	67/33.1%	42/21%
Нийгмийн хүрээлэл	2	110/54%	66/33%	26/13%
Шашин шүтлэг	9	74/37%	95/47%	33/16%

Хүснэгт 3. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлсон байдал

Та эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажил, арга хэмжээг хэрхэн тодорхойлох вэ?	F	1=их/2=дундаж/3=бага		
		1	2	3
Түүх, соёл уламжлалаа сэргээн хөгжүүлэх	1	144/76%	30/16%	15/8%
Бүх шатны боловсролын агуулгыг өөрчлөх	3	127/67%	24/13%	38/20%
Хууль, эрх зүйн орчныг сайжруулах	4	104/55%	43/23%	42/22%
Иргэдийн ёс суртахууныг дээшлүүлэх	2	101/53%	41/22%	49/26%
Хариуцлагын тогтолцоог бий болгох	5	128/68%	24/12.6%	37/19.4%
Эх оронч үзлээр өөрийгөө хөгжүүлэх	6	99/52%	39/21%	49/26%

Хүснэгт 4. Иргэдээс эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлсон байдал

Та эх оронч үзлийг төлөвшүүлэх ажил, арга хэмжээг хэрхэн тодорхойлох вэ?	F	1=их/2=дундаж/3=бага		
		1	2	3
Түүх, соёл уламжлалаа сэргээн хөгжүүлэх	2	142/70%	33/17%	27/13%
Бүх шатны боловсролын агуулгыг өөрчлөх	6	129/64%	43/21%	30/15%
Хууль, эрх зүйн орчныг сайжруулах	4	133/66%	46/23%	23/11%
Иргэдийн ёс суртахууныг дээшлүүлэх	1	144/71%	44/22%	14/7%
Хариуцлагын тогтолцоог бий болгох	3	135/67%	47/23%	20/10%
Эх оронч үзлээр өөрийгөө хөгжүүлэх	5	131/65%	54/27%	17/8%

Судалгаанаас үзэхэд Хил хамгаалах байгууллагын алба хаагчид болон энгийн иргэд эх оронч

үзлийг төлөвшүүлэхэд ёс суртахууны асуудлыг чухалчилсан бөгөөд боловсролын агуулгыг өөрчлөх,

хариуцлагын тогтолцоог бий болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах, эх оронч үзлээр өөрийгөө хөгжүүлэх зэрэг ажлуудыг хийх шаардлагатай гэж үзсэн бөгөөд энэ нь эх оронч үндэсний үзэл, ёс суртахууны хамаарлыг тодорхой илэрхийлсэн агуулгатай байна.

Хоёр. Сэтгэлийн боловсрол.

Өнөөгийн нийгэмд өдөр бүр тохиолдох ёс суртахуунгүй үйлдлүүдийг эгэл жирийн иргэдээс төрийн түшээд хүртэл гаргах болсон нь мэдлэг гэх харьцангуй ойлголт буюу оюуны боловсролыг шүтэж сэтгэлийн боловсролыг орхигдуулсантай холбоотой.

Сэтгэлийн боловсрол бол хүнийг хүн болгодог үндсэн шинж буюу ёс суртахууны тухай мэдлэгийн цогц бөгөөд хүнлэг энэрэнгүй байх тухай ойлголт юм. Дээрхийн гэгээнтэн 14 дүгээр далай лам “Өнгөрсөн зуунд хүн төрөлхтөн шинжлэх ухаанд их нээлтийг хийж, боловсролын өндөр түвшинд гарч ирсэн боловч дайн дажин, муу муухай зүйл, хорсол, занал арилж үгүй болохгүй, харин ч даамжрах хандлагатай байна. Өнөөгийн хүн төрөлхтөнд оюуны хийгээд сэтгэлийн боловсролыг хослуулан хэрэгжүүлэх нь нэн чухал боллоо” гэж хэлсэн байдаг.

Сэтгэлийн боловсролыг оюуны боловсролтой нягт уялдуулах, ёс суртахуунд суурилсан боловсрол олгох нь маш чухал бөгөөд энэ асуудалд дараах хүчин зүйлс онцгой ач холбогдолтой юм. Үүнд:

-Хүнээр хүн хийх үндэсний уламжлалт арга ухааныг сурталчлах, сэргээн хөгжүүлэх;

-Ёс суртахууны “Хүнлэг энэрэнгүй” байх зарчмыг нийгмийн бүхий л түвшинд сурталчлан таниулах;

-Гэр бүлийн хүмүүжил буюу, эх, эцгийн ёс суртахууны нөлөөллийг сайжруулах;

-Бүх шатны боловсролын байгууллагын ёс суртахууны сургалтын агуулгыг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, багшийн сэтгэлийн боловсролын түвшинд анхаарал хандуулах;

-Эх орон, тусгаар тогтнолын баталгаа, бахархлыг сурталчлах.

-Нийгмийн шударга ёс, үнэнч байдлыг цогцлоон бий болгох.

-Материаллаг ашиг сонирхолд бус хүн төрөлхтөний үнэт зүйл болох ёс суртахуунд суурилсан ашиг сонирхлыг дээдлэх.

-Эх орныхоо эрх ашгийг явцуу эрх ашгаас ямагт дээгүүрт тавьдаг хариуцлагатай байх зэрэг хамаарах бөгөөд эдгээр нь сэтгэлийн боловсролын гол үнэлэмж байх учиртай.

Сэтгэлийн боловсролыг эх орныхоо хөгжлийн түлхүүр болгон тодорхойлж түүнийг ёс суртахууны мэдрэмж бүхий эх оронч үндэсний үзэлтэй уялдуулан төлөвшүүлж буй улс орнууд олон байна. Зарим улс орны туршлагыг судлан авч үзье.

1. Япон хүхдүүдийн дунд “Сур сур илүү ихийг сур” гэдэг уриа сургалтын гол язгуур зарчим болдог

бөгөөд “Мэдсэнээ чадахгүй байснаас огт мэдэхгүй байсан нь дээр” гэсэн Японы зүйр үг ч байдаг. Энэ улсад ноёрхдог шашин гүн ухааны номлол болох “Кокоро” хэмээх “зүрх сэтгэл, хүнлэг ёс” гэсэн утга бүхий ойлголтын тусламжтайгаар хүүхэд, өсвөр үеийнхэн бүх амьд амьтан, хүнийг хүндэтгэн хайрлаж энэрэх, өгөөмөр сэтгэлээр, үнэнч шударгаар хандах, үнэнийг эрж хайх, гоо сайхныг мэдрэх чадвар, өөрийгөө эзэмдэх, байгалиа хамгаалах, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах зэрэг бие хүний хамгийн эерэг эрхэм чанаруудыг төлөвшүүлэхэд тусалдаг”¹ байна. “...Японд 3-4 дүгээр ангийн сурагч байх үеэс л өөрийн ёс зүйн хүрээнд өөрт хамааралтай зүйлээ өөрөө хийх, шийдсэн зүйлдээ тууштай зүтгэх, өөдрөг, зоригтой үнэнч шударга байж өөрийн давуу талаа хөгжүүлэхэд сургадаг бөгөөд бусадтай харилцах ёс зүйн хүрээнд хэнтэй ч чин сэтгэлээсээ харьцах, бусдыг хүндэтгэх, эелдэг зөөлөн хандах, найз нөхөдтэйгээ харилцан итгэлцэн ойлголцох, бусдыг хүндэтгэн талархах, ёс журамтай байхад суралцдаг. Харин хамт олон, нийгэмтэй харилцах ёс зүйн хүрээнд нийгмийн ёс зүй, дүрэм журмыг хүндэтгэн сахих, эцэг, эх багшаа хүндэтгэх, эх орон, газар нутаг, хил хязгаараа хайрлах, уламжлал соёлоо

хүндэтгэн судлах, амлалтандаа хүрдэг байх үзэл төлөвшдөг...”² байна. Байгаль орчноо хүндэтгэн хайрлах ёс зүйн хүрээнд үзэсгэлэнт байгалийг хараад биширч бахархах, түүнийг хайрлан хамгаалах, амьдралын утга учир, үнэ цэнийг мэдэрч хайрлах үзэл төлөвшисөн байх бөгөөд энэ бүхэн агуулгын хувьд уялдаж япон хүн бүрт байх ёс зүйн төлөвшил, эх оронч үзлийн гол үзүүлэлт болж сэтгэлийн боловсролын үндсэн агуулгыг бий болгожээ.

2.ОХУ хурдацтай хөгжиж байгаагийн гол шалтгаан нь эх оронч үзэл бол хувь хүний ёс суртахууны мэдрэмж юм гэж үзэх үзэл бөгөөд ёс суртахууны мэдрэмжид “эх орондоо хайртай байх”, “улс төрийн байгууламжийг хүлээн зөвшөөрөх”, “уламжлалыг түгээн дэлгэрүүлэх”, “түүхэн хөшөө дурсгал, төрөлх эх орныхоо ёс, зан заншилд хүндэтгэлтэй хандан хамгаалах”, “төрж өссөн нутаг орноо хайрлан дээдэлдэг байх”, “эх орны нэр төр, давуу талыг бэхжүүлэхийг эрмэлзэх”, “эх орноо хамгаалах чадварыг эзэмших, байнга бэлэн байх” зэргийг хамааруулан тодорхойлсон² явдал юм. Иргэнд сургуулийн насанд нь эх оронч ёс суртахууны мэдрэмж төлөвшүүлэх шаардлагыг чухалчилан “боловсролынхоо тогтолцоонд өөрчлөлт оруулж, ёс суртахууныг заавал үзэх хичээл

¹ Тэгшжаргал Н. Хүмүүнших боловсрохуйн ухаан. –Уб., 2013. 36 дахь тал.

² Япон улсын боловсрол шинжлэх ухааны яам.”Дунд сургуулийн боловсролын

стандартын тайлбар” Геосэй хэвлэлийн компани. 2008 он.

² Концепция модернизации образования РФ до 2010 г. вестн. образования. №3

болгоод, сурах бичгүүдийг нь гаргаж өгсөн”³ байна. Үүнээс гадна иргэдийг, ялангуяа өсвөр залуу үеийнхэнд эх орныхоо түүхийг хүндэтгэн судлах сонирхол төрүүлэх, эх орныхоо төлөө тэмцэгчдийн түүхэн гавьяаг дурсан хүндэтгэх, эх нутаг байгалийн сайхныг хайрлан, оросын утга зохиол, соёл урлагийг сонирхосноор эх орноороо бахархах мэдрэмжийг хөгжүүлж байна.

XX зууны сүүл XXI зууны эхээр орос оронд нийгэм, эдийн засаг, улс төрийн хямралтай зэрэгцэн эх оронч үзэл, ухамсрын доголдол бий болсон нь манай улсад тохиолдсон бэрхшээлтэй адил боловч эх оронч үзэл нь иргэд өөрийн эх орондоо хандах хандлагыг тодорхойлдог нийгэм, ёс суртахууны ухамсар мөн гэсэн зарчмыг ард түмэндээ төлөвшүүлсэн нь ирэдийх нь сэтгэлийн боловсролын гол агуулга болжээ.

3. БНХАУ-ын дунд сургуулийн 3-6 дугаар ангийн сурагчдад сэтгэлийн боловсролыг олгохдоо нийгэм болон ёс зүйн хичээлийн нэгдэл “Ёс суртахуун ба нийгэм” гэсэн хичээлийг үзэл бодол, үнэлэмж, мэдлэг, ур чадвар гэсэн шалгуурын хүрээнд заадаг байна. Өөрийгөө танин мэдэх буюу өөрт хамааралтай ёс зүйн хэм хэмжээний хүрээнд тухайн хүүхдийн өөрийн сайн талыг хөгжүүлэх өөртөө итгэлтэй байх,

өөрийгөө хүндэтгэн нэр төрөө хайрлах, муу зүйл хийхдээ бусдаас эмээдэг байх, арвич хямгач байх, ажилч хичээнгүй байх, үйлдлээ эргэн харж буруугаа хүлээдэг, бэрхшээл хүндрэлийг даван туулж суралцаж чаддаг байх зэрэг чадварыг төлөвшүүлснээр хамт олон дунд суралцаж, ажиллаж, амьдарч болно гэж үздэг. Харин бусадтай харилцахад баримтлах ёс зүйн хүрээнд бусдын сайн чанарыг ойлгож хүндэтгэх, бусдад уужим сэтгэлээр хандах, амлалтаа биелүүлэх, гэр бүлийнхээ өмнө хүлээх хариуцлагаа мэдэрдэг байх, гэр бүл, багш нараа хүндэтгэх, анд нөхдийн харилцааг эрхэмлэн найз нөхдөө хайрлах, харилцан ойлголцох, эрүүл соёлтой амьдралд суралцах, хөршүүд болон бусадтай найрсаг харилцах чадвартай болсон байдаг¹ байна. Хятад хүүхдүүд хамт олон, нийгэмтэй харилцахад хамаарах ёс зүйн хэм хэмжээний хүрээнд эх орноо хайрлах, бахархах, ёс зүй, хууль тогоомжийг дээдлэх, аюулгүй байдлын ерөнхий мэдлэгтэй болох, хамт олны ажилд оролцох, харилцан ойлголцох, хамтран ажиллах мэдлэг, чадвартай болдог төдийгүй ёс зүйн хүрээнд байгаль орчноо хайрлан хамгаалах, өөрийн ба бусдын амь насыг хайрлах, соёл уламжлалаа хүндэтгэн бахархах, шинжлэх ухааныг хүндэтгэх зэрэг үзэл

³ Нарангэрэл С. “Ёс зүйг дээдлэхүй”. –Уб., 2014. 12 дахь тал.

¹ БНХАУ-ын Боловсролын яам. “Албан ёсны боловсрол дахь ёс суртахуун, нийгмийн

ухааны хичээлийн стандарт”. Бээжингийн их сургуулийн харьяа хэвлэлийн компани. 2002 он

төлөвшсөн байдаг нь хятад иргэний сэтгэлийн боловсролын цөмийг бий болгожээ.

Эдгээр улс орнуудын иргэдийн сэтгэлийн боловсрол нь оюуны боловсролтой зэрэгцэн, зарим тохиолдолд тэргүүн зэрэгт үнэлэгдэж байгаа нь тухайн улсуудын хөгжлийн гол түлхүүр гэж үзэж болох юм.

Дүгнэлт, санал

Манай Улсад ёс суртахуун болон эх оронч үндэсний үзлийг эх орны хөгжлийн чухал асуудал болгон томъёолж, тэдгээрийг төлөвшүүлэх тухай эрх зүйн баримт бичгүүд олон байдаг ба түүн дотор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт “...хүмүүнлэг, оюунлаг, *ёс суртахуунтай* эх оронч, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх...” гэж, Монгол Улсын “Боловсролын ерөнхий хууль”-ийн 4.1-т боловсролын зорилгыг “...хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцан ажиллах, *ёс суртахуунтай, сайн зан чанартай* иргэнийг төлөвшүүлэх...” гэж заасан нь цаг үеэ олсон чухал хэм хэмжээ болсон гэж үзэж байна.

Сэтгэлийн боловсролын гол асуудал болох ёс суртахуун, эх оронч үндэсний үзэлд хэрхэн нөлөөлөх, түүнийг төлөвшүүлэх үндсэн арга хэмжээг тодорхойлох зорилгоор Хил хамгаалах байгууллагын албан хаагчид болон энгийн иргэдээс судалгаа авахад ёс суртахууны асуудлыг чухалчилсан бөгөөд,

боловсролын агуулгыг өөрчлөх, хариуцлагын тогтолцоог бий болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах, эх оронч үзлээр өөрийгөө хөгжүүлэх зэрэг ажлуудыг хийх шаардлагатай гэж үзсэн нь эх оронч үндэсний үзэл, ёс суртахууны хамаарлыг тодорхой илэрхийлжээ.

Сэтгэлийн боловсрол бол хүнийг хүн болгодог үндсэн шинж буюу ёс суртахууны тухай мэдлэгийн тухай цогц бөгөөд хүнлэг энэрэнгүй байх тухай ойлголт учраас түүнийг оюуны боловсролтой нягт уялдуулж, ёс суртахуунд суурилсан боловсрол олгохдоо гэр бүлийн хүмүүжил буюу, эуэг, эхийн ёс суртахууны нөлөөллийг сайжруулах, бүх шатны боловсролын байгууллагын ёс суртахууны сургалтын агуулгыг өөрчлөх, багшийн сэтгэлийн боловсролын түвшинг нэмэгдүүлэх, хүнээр хүн хийх уламжлалт арга ухааныг сэргээн хөгжүүлэх, нийгмийн шударга ёс тогтоох, материаллаг ашиг сонирхолд бус хүн төрөлхтөний үнэт зүйл болох ёс суртахуунд суурилсан ашиг сонирхлыг дээдлэх, эх орныхоо эрх ашгийг явцуу эрх ашгаас ямагт дээгүүрт тавьдаг хариуцлагатай байх зэрэг асуудлыг чухалчлах учиртай.

Сэтгэлийн боловсролыг эх орныхоо хөгжлийн түлхүүр болгон тодорхойлж түүнийг ёс суртахууны мэдрэмж бүхий эх оронч үндэсний үзэлтэй уялдуулан төлөвшүүлж буй гадаад орнуудын туршлагыг харахад хүүхэд залуусыг хүнлэг энэрэнгүй, үүргээ ухамсарласан нийгмийн

хариуцлагатай, эх орноо хайрлаж бахархдаг, улсынхаа аюулгүй байдлыг хангахад ёс суртахуун, сэтгэл зүйн хувьд бэлтгэгдсэн байх гол агуулгад суурилсан нь нийтлэг бөгөөд эдгээр нь манай улсын нийгмийн хөгжил, улсын аюулгүй байдалд чухал ач холбогдолтой туршлага болохоор байна.

Эх сурвалжийн жагсаалт

- БНХАУ-ын Боловсролын яам. “Албан ёсны боловсрол дахь ёс суртахуун, нийгмийн ухааны хичээлийн стандарт”. Бээжингийн их сургуулийн харьяа хэвлэлийн компани. 2002 он
- “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, хүн амын оюуны

дархлааны асуудал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.-Уб. 2015.

- Чанышев А.Н. Курс лекции по древней философии. -М.,1981.

- Тэгшжаргал Н. Хүмүүнших боловсрохуйн ухаан. -Уб., 2013.

- Япон улсын боловсрол шинжлэх ухааны яам.”Дунд сургуулийн боловсролын стандартын тайлбар” Геосэй хэвлэлийн компани. 2008 он.

- Концепция модернизации образования РФ до 2010 г. вестн. образования. No3

- Нарангэрэл С. ”Ёс зүйг дээдлэхүй”. - Уб., 2014.